



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ,
ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ БАЙНА**

**2024 оны 05
дүгээр сар**

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023
ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Айнур

Утас: 94159291 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn

Аудитор: С.Нурлан

Утас: 99103281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

2024 он

АГУУЛГА

АГУУЛГА	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товьёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
А. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЧ ХОЛБОГДЛЫН ЭРЭМБЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ДАРААЛЛЫГ ОЛОН НИЙТИЙН САНАЛД ҮНДЭСЛЭЭГҮЙ БАЙНА.	7
А.1. Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй байна	7
А.2. Төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцсон байна	9
А.3. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна	10
Б. ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 89.5 ХУВЬ НЬ ТАЙЛАНТ ОНД ХЭРЭГЖИЖ, ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА	12
Б.1. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 89.5 хувийг хугацаанд хэрэгжүүлэн ажилласан байна	12
Б.2. Төсөл, арга хэмжээнд холбогдох хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна	13
Б.3. Ашиглалтад хүлээн авсан зарим төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд бүртгэлд тусгаагүй байна	13
В. ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН ТАЛААР НОТЛОХ БАРИМТААР ДЭМЖИГДЭЭГҮЙ БАЙНА	14
В.1. Хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүд зориулалтын дагуу ашиглагдаж байна	14
В.2. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан талаар судалгаа хийгдээгүй, нотлох баримтаар дэмжигдээгүй байна	15
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	16
ДҮГНЭЛТ:	17
ЗӨВЛӨМЖ:	18

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	
МСҮт	
ХХК	

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	Төсөл арга хэмжээний өртөг, санхүүжих дүн	7
Хүснэгт 2	Төсөл арга, хэмжээний төсөвт өртөг, гэрээний дүн, ажлын гүйцэтгэлийн дүн	10
Хүснэгт 3	Санхүүжилтийн мэдээлэл, ажлын гүйцэтгэл	11

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/100 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх,
- Хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх,

Аудитын хамарсан хүрээ

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг Аймгийн Засаг дарга түүний харьяа Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Барилга захиалагчийн алба зэрэг холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах,

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Айнур, аудитор С.Нурлан нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 4 дүгээр сарын 25-наас 5 дугаар сарын 17-ны дотор гүйцэтгэсэн ба тайлагналын үе шатны ажлыг 2024 оны 5 дугаар сарын 18-наас эхлүүлж, 5 дугаар сарын 25-ны хооронд хийж, 6 дугаар сарын 05-ны дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

Байхгүй

А. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

А.1. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй, ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслээгүй байна

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 сарын 02-ны өдрийн 132 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих их засварын нийт төсвийг 1,351.2 сая төгрөгөөр баталсан бөгөөд төсөл арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар батлаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.6-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, санхүүжилтийн эх үүсвэрээр/” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн “Аймгийн 2023 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай” 192 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн боловсрол, соёлын салбарт 2023 онд хийгдэх их засварын төсвийг төсөл арга хэмжээ тус бүрээр 1,351.2 сая төгрөгөөр, тоног төхөөрөмж худалдан авах төсвийг нийт дүнгээр 735.2 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн “Аймгийн 2023 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай” 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн боловсрол, соёлын салбарт 2023 онд хийгдэх их засварын төсвийг төсөл арга хэмжээ тус бүрээр 1,351.2 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын их засварын урьд оны үлдэгдэл санхүүжилтийг 297.5 сая төгрөгөөр, тоног төхөөрөмж худалдан авах төсвийг нийт дүнгээр 735.2 сая төгрөгөөр хэвээр баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт төсвийн 62.2 хувийг их засварт, 30.8 хувийг тоног төхөөрөмж худалдан авахад төлөвлөжээ.

Хүснэгт № 01

Д/д	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	ТАХ-ын тоо	Төсөвт өртөг /сая төгрөгөөр/	Санхүүжих дүн
1	Шилжих хөрөнгө оруулалт	7	777.3	486.9
2	Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ	32	1,460.5	1,179.7
3	Тоног төхөөрөмж	-	735.2	735.2
	Нийт дүн	39	2,973.0	2,401.8

Эх сурвалж: ОНТХО-ын төсөв баталсан Аймгийн ИТХ-ын тогтоол

Шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжих 7 төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 777.3 сая төгрөгөөр, санхүүжих дүнг 486.9 сая төгрөгөөр, шинээр хэрэгжих 32 төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 1,460.5 сая төгрөгөөр, санхүүжих дүнг 1,179.7 сая төгрөгөөр баталсан байна.

Шинээр хэрэгжих 1,460.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсөл арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх

дарааллыг олон нийтийн саналд үндэслээгүй, барилга байгууламжийн ашиглалтын талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй байна.

Үүнээс 253.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын 15 төсөл арга хэмжээний төсвийг 5.0-20.0 сая төгрөгөөр хэт жижиглэн төлөвлөсөн нь урсгал засварын шинжтэй хөрөнгө оруулалт болсон ба засварын нийт төсөл арга хэмжээний 46.8 хувийг эзэлж байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь энэ журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 2.1.2.1-д “төслийн саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх”, 2.1.2.2-д “төслийн саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төслүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах”, 3 дугаар зүйлийн 3.2.3-т “их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөлд дараах шаардлагыг тавина”, 3.2.3.4-т “тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 192, 197 дугаар тогтоолоор тоног төхөөрөмж худалдан авахад 735.2 сая төгрөгийн төсөв баталсан боловч холбогдох байгууллагуудаас санал аваагүй, чухал хэрэгцээ шаардлага байсан эсэх талаар тооцоо, судалгаа хийгээгүй, нотлох баримтаар дэмжигдээгүйн дээр тоног төхөөрөмж худалдан авах зардлыг төсөл арга хэмжээ тус бүрээр батлаагүй нийт дүнгээр баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хууль 29 дүгээр зүйлийн 29.3.3-т “нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах”, 29.3.4-т “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах”,

Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1-т “Захиалагч төрийн байгууллага, албан газар, төрийн болон орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газрын төсвийн шууд захирагч, гүйцэтгэх удирдлага нь төлөвлөгөө, тайланг баталж, дараах үе шатаар холбогдох дээд шатны байгууллагад цахим системээр ирүүлнэ”, 3 дугаар зүйлийн 3.2-т “Захиалагч тухайн жилийн төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын маягт 1-ийн дагуу боловсруулж, түүнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, төсөвт өртөг, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга, хэрэгжүүлэх хугацаа болон холбогдох тайлбар, тодруулга зэрэг мэдээллийг тодорхой тусгасан байна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 1,460.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын 32 төсөл арга хэмжээ, тоног төхөөрөмж худалдан авах 735.2 сая төгрөгийн төсөл арга хэмжээг холбогдох журамд нийцүүлэн төлөвлөөгүй, төлөвлөлтийн шатанд холбогдох нотлох баримтыг бүрдүүлж

ажиллаагүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.3-т “холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх” заалтыг зөрчсөн байна.

Аудитын дүнгээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, холбоглох журамд нийцүүлэн төлөвлөж ажиллахыг аймгийн Засаг дарга, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст зөвлөмж болгов.

Шинээр хэрэгжих их засварын 32 төсөл арга хэмжээний зураг төсөл, төсөв нь хийгдэж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд 2 төсөл арга хэмжээг нээлттэй, 14 төсөл арга хэмжээг харьцуулалтын тендер шалгаруулалтын аргаар хууль журмын дагуу цахим хэлбэрээр, 16 төсөл арга хэмжээг шууд гэрээ хийх замаар зохион байгуулжээ.

Баяннуур сумын ахуй үйлчилгээний барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгон засварлах төсөл арга хэмжээний нээлттэй тендерийн худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, шууд гэрээгээр худалдан авах Өлгий сумын 4 дүгээр цэцэрлэгийн халаалтын засвар төсөл арга хэмжээ хугацаанд хэрэгжих боломжгүй болж дараа онд шилжсэн байна.

Боловсрол, соёлын салбарын засварын ажлын тендер шалгаруулалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 16-ны өдрийн хооронд, шууд гэрээг 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулжээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1.-д “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах”, 13.1.2-т “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын дүнгээр Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга, Худалдан авах ажиллагааны газарт зөвлөмж болгов.

А.2. Төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцсон байна

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 197 дугаар тогтоолын 2, 4 дүгээр хавсралтаар баталсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 39 төсөл арга хэмжээний анхны төсөвт өртөг нь 2,293.0 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 2,401.8 сая төгрөг, гэрээний дүн 2,627.0 сая төгрөг байна.

Хүснэгт № 02

Төсөл, арга хэмжээний нэр	Шинэ, шилжих	TAX-ний тоо	Анх төлөвлөсөн дүн	2023 онд санхүүжих дүн	Гэрээний дүн
Засвар	шилжих	7	777.3	486.9	768.0
Засвар	шинэ	32	1,460.50	1179.7	1,133.4
Тоног төхөөрөмж	шинэ	1	735.20	735.2	725.60
Нийт		40	2,973.0	2,401.8	2,627.0

Эх сурвалж: ОНТХО-ын төсөв баталсан Аймгийн ИТХ-ын тогтоол

Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцсон эсэхийг судалж үзэхэд 2022 оноос шилжин хэрэгжсэн 7 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 486.9 сая төгрөгийг бүрэн олгож, төсөл арга хэмжээг хэрэгжиж дуусахаар, шинээр хэрэгжих 32 төсөл арга хэмжээний нийт өртгийн 80.8 хувийг санхүүжүүлэхээр, тоног төхөөрөмж худалдан авах 735.2 сая төгрөгийн төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах” гэсэнтэй нийцсэн бөгөөд шинээр хэрэгжих их засварын 2023 онд олгох санхүүжилтийг 80 хувиар, дараа онд шилжих санхүүжилтийг 20 хувиар тооцсон нь төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжүүлэх боломжтой байдлаар төлөвлөсөн байна.

Төсөл арга хэмжээнээс шилжих болон шинээр хэрэгжих 32, тоног төхөөрөмж худалдан авах 1 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, шинээр хэрэгжих 4 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, дараа онд шилжсэн байна.

А.3. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн их засварын 37 төсөл арга хэмжээ, тоног төхөөрөмж худалдан авах гэрээний нийт дүн 2,627.0 сая төгрөг ба ажил эхэлснээс хойш олгосон санхүүжилтийн дүн 2,439.5 сая төгрөг, 2023 онд олгосон санхүүжилт 2,171.3 сая төгрөг байна.

Хүснэгт 03

Төсөл, арга хэмжээний нэр	Шинэ, шилжих	TAX-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Ажил эхэлснээс хойших санхүүжилт	2023 онд олгосон санхүүжилт	Хувь
Засвар	шилжих	7	777.3	768.00	761.90	494.60	0.99
Засвар	шинэ	32	1,460.50	1,133.4	951.70	950.80	0.84

Тоног төхөөрөмж	шинэ	1	735.20	725.60	725.90	725.90	100.0
Нийт дүн		40	2,973.0	2,627.0	2,439.5	2,171.3	

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

Их засварын 2022 оноос шилжин хэрэгжсэн 7 төсөл арга хэмжээний 6 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ашиглалтад оруулан, урьд онд бүрэн хэрэгжсэн 1 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг олгосон байна.

Шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнд 494.6 сая төгрөг санхүүжилт олгосон. Шинээр хэрэгжих гэрээний дүн нь 1,133.4 сая төгрөгийн 30 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 951.7 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс зохих хяналтыг хэрэгжүүлж, төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон боловч баримтын бүрдүүлэлт, гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчил дутагдал илэрлээ.Үүнд:

- Зарим төсөл арга хэмжээний гэрээг дүгнэсэн акт үйлдээгүй, төсөл арга хэмжээний улсын комиссын гишүүдийн саналын хуудсыг хавсаргаагүй, зураг төслийн хяналт тавигдсан талаар нотлох баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, төсөл арга хэмжээний зураг төслийн хяналтын зардлыг гүйцэтгэгч компанид олгосон, төсөл арга хэмжээний магадалшгүй ажлыг дүгнэсэн акт үйлдээгүй, ашиглалтад оруулсан төсөл арга хэмжээний орлогод авсан баримтыг бүрдүүлж хавсаргаагүй байна.

Аудитын дүнгээр төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо бүрдүүлэх материалын иж бүрдлийг хангаж Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст зөвлөмж болгов.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг хүүхдийн цэцэрлэгийн зориулалттай болгож засварлах төсөл арга хэмжээний зураг төслийн зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч “Лаулау” ХХК-д олгосон зураг төслийн зохиогчийн хяналтын зардал 802.3 мянган төгрөг, Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны /75А/ корпусын засварын ажлын зураг төслийн зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч “Едилжайых” ХХК-д олгосон зураг төслийн зохиогчийн хяналтын зардлын 341.7 мянган төгрөгийн бүгд 1,144.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Тоног төхөөрөмж худалдан авах 725.6 сая төгрөгөөр 129 ширхэг зөөврийн Dell компьютер, Canon 3010 маркийн 3 үйлдэлтэй 129 ширхэг принтер, 115 ширхэг “СТ system 6.0” нягтлан бодох бүртгэлийн программыг худалдан авч, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн төсвийн 23, улсын төсвийн 95 бүгд 118 байгууллагад олгожээ. Үүнээс: Улсын төсвийн ерөнхий боловсролын 38 сургууль, 45 хүүхдийн цэцэрлэг, улсын төсвийн бусад 12 байгууллагад байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт дансны зарцуулагдаагүй 183.0 сая төгрөгийн үлдэгдлийг оны эцэст барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

Б. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 89.5 ХУВЬ НЬ ХЭРЭГЖСЭН БОЛОВЧ ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ БАЙНА

Б.1. Төсөл арга хэмжээний 89.5 хувийг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлсэн байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 39 төсөл арга хэмжээний 1 нь үлдэгдэл санхүүжилт олгох төсөл арга хэмжээ бөгөөд хэрэгжсэн 38 төсөл арга хэмжээний 34 нь тайлант онд хэрэгжих, 2 нь хэрэгжээгүй, 2 нь он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ байна.

Тайлант онд хэрэгжих 36 төсөл арга хэмжээний 32 нь бүрэн хэрэгжиж, ашиглалтад хүлээн авчээ. Тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээг техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагын дагуу гэрээний хугацаанд бүрэн хүлээн авсан байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 89.5 хувийг хугацаанд хэрэгжүүлж ажилласан байна.

Хугацаандаа хэрэгжээгүй их засварын 4 төсөл арга хэмжээ нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Аймгийн Хөгжимт драмын театрын дээврийн засварын төсөл арга хэмжээний ажлын явцыг 83.1 хувьтай, Булган сумын цэцэрлэгт зуух худалдан авах ажлын явцыг 64.5 хувьтай гэж тайлагнасан нь худалдан авах ажиллагааг хэрэгжих боломжтой хугацаанд зохион байгуулаагүйгээс төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, Баяннуур сумын Ахуй үйлчилгээний барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгон засварлах 304.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын худалдан авах ажил амжилтгүй болсноос, Өлгий сумын 4 дүгээр цэцэрлэгийн 19.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй халаалтын засварын ажил худалдан авах ажлыг хэрэгжих боломжтой хугацаанд зохион байгуулаагүйгээс дараа онд шилжсэн байна.

Аудитын явцад аймгийн төв болон Бугат сумд хэрэгжсэн засварын 10 төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн эсэхийг газар дээр нь шалгаж үзэхэд:

- Өлгий сумын 2 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын ажил, 16, 9, 4 дүгээр цэцэрлэг, ерөнхий боловсролын 5, 7, 9 дүгээр сургууль, Бугат сумын сургуулийн хичээлийн байр, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны засварын ажлыг зураг төсвийн дагуу хийсэн. Өлгий сумын 14 дүгээр цэцэрлэгийн засварын ажлын гарцын гэрэл, аваарын дохиоллын ажлыг дутуу хийсэн байна.

Тайлант онд хэрэгжсэн 32 төсөл арга хэмжээний 253.7 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээ буюу 46.8 хувь нь 5.0-20.0 сая төгрөгөөр шууд гэрээгээр гүйцэтгүүлсэн урсгал засварын шинжтэй төсөл арга хэмжээ байна. Засварын ажлын төсвийг хэт жижиглэн бага дүнтэй олон арга хэмжээ болгон төлөвлөж хэрэгжүүлсэн нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулсан байна.

Б.2. Төсөл, арга хэмжээнд холбогдох хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна

Аймгийн Засаг даргатай хийсэн гэрээний дагуу Барилга захиалагчийн алба их засварын 35 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засварын ажлын хяналтыг Булган сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/106 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг болон захиалагч тал өөрсдөө хэрэгжүүлсэн байна.

Төлөвлөсөн хугацаанд хэрэгжсэн 32 төсөл арга хэмжээний хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна.

Ашиглалтад хүлээн авах комисс нь төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авахдаа “Барилга байгууламжийн төсөл арга хэмжээнд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хуудас”-ыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу хөтөлж, үүрэг даалгаврын биелэлтийг тооцож, ашиглалтад хүлээн авах актыг үйлдсэн байна.

Тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээнд аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/480 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий нягтлан бодогч, Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн харьяа Төрийн үйлчилгээ-мэдээллийн төсвийн эрхлэгч, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Орон нутгийн өмчийн газрын холбогдох мэргэжилтнүүд хяналтыг хэрэгжүүлж, хүлээн авсан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс олгосон байна.

Б.3.Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагууд бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулаагүй байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 171.7 сая төгрөгийн барилгын их засварын 3 төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагууд орлого авч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй. Үүнд:

- ✓ Улаанхус сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн их засварын үнийн зөрүү 69.6 сая төгрөгийн,
- ✓ Хотгор багийн бага сургуулийн халаалтын зуух солих төсөл арга хэмжээний 5.0 сая төгрөгийн
- ✓ МСҮТ-ийн дотуур байрны засварын 97.1 сая төгрөгийн нийтдээ 171.7 сая төгрөгийн их засварыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудад олгосон 725.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагууд орлого бүрэн авсан эсэх нь тодорхойгүй, тухайн байгууллагууд орлого авсан эсэхийг баримтжуулаагүй, төсөл арга хэмжээг хүлээн авах ажлын хэсэг үүргээ хангалтгүй хэрэгжүүлжээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулж баримтжуулаагүй байгаа нь өмч хөрөнгө бүртгэлээс завсардах, эзэнгүйдэх эрсдэлийг бий болгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 2-т *"Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д *"нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг, заавал бүртгэнэ"*, 14.4.2-т *"бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"*, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан *"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"*-ын 4.1.31-д *"Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана"*, 4.2.6-д *"Захиалагч нь төслийн эцсийн санхүүжилтийн хүсэлтийг ирүүлэхдээ барилга байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна"*, 5.3.3-д *"Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана"*, 5.3.5-д *"Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу шийдвэрлэнэ"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитын дүнгээр Санхүү, төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газарт төсөвт байгууллагуудад олгосон тоног төхөөрөмж, санхүүгийн программыг нягтлан бодох бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулж, баримтжуулан зөрчил арилгах албан шаардлага хүргүүллээ.

В. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН ЭСЭХ НЬ НОТЛОХ БАРИМТААР ДЭМЖИГДЭЭГҮЙ БАЙНА

В.1. Хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүд зориулалтын дагуу ашиглагдаж байгаа боловч үр дүнг тооцоогүй байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн их засварын 32 төсөл, арга хэмжээнүүдийг ашиглалтад оруулах улсын комисс хүлээн авч, ашиглагч байгууллагууд нь зориулалтын дагуу ашиглаж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засварын 20, хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засварын 10, Соёл байгууллагын барилгын их засварын 2 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжсэний үр дүнд барилга байгууламжийн ашиглалтын хугацааг уртсаж, өнгө үзэмж сайжирч, сургалтын ая тухтай орчин бүрдсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 725.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 118 төсөвт байгууллагад олгосон ба аудитаар тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагууд бүрэн хүлээн авч ашиглаж байгаа эсэхийг түүвэрлэн шалгаж үзэхэд хүлээн авч данс бүртгэлд тусгасан эсэхийг баталгаажуулж

баримтжуулаагүй байна. Төсөвт байгууллагууд нийлүүлсэн санхүүгийн программыг зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.

В.2. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан эсэх талаар судалгаа хийгдээгүй байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан талаар судалгаа, тооцоо хийгдээгүй, нотлох баримтаар дэмжигдээгүй байна.

Тайлан онд хэрэгжиж, ашиглалтад хүлээн авсан их засварын 32 төсөл арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн боловч 377.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээ нь хэрэгжээгүй, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

Тухайлбал: Аймгийн Хөгжимт драмын театрын 42.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дээврийн засвар, Баяннуур сумын Ахуй үйлчилгээний барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгох 304.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засвар, Өлгий сумын 4 дүгээр цэцэрлэгийн 19.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй халаалтын засвар, Булган сумын цэцэрлэгт зуух худалдан авах 11.0 сая төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээ нь хэрэгжээгүй, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

Тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд 115 төсөвт байгууллагад 129 ширхэг Dell зөөврийн компьютер, 129 ширхэг Canon 3010 маркийн 3 үйлдэлт принтер, 115 ширхэг "CT system 6.0" нягтлан бодох бүртгэлийн программ нийлүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүгийн программыг онлайн горимд шилжүүлэх, зөөврийн компьютерийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага байсан эсэх талаар Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс уг арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан талаар судалгаа хийгдээгүй, нотлох баримтаар дэмжигдээгүй байна.

118 төсөвт байгууллагад тоног төхөөрөмж олгосны 23 нь орон нутгийн төсөвт байгууллагууд, 95 нь улсын төсвийн байгууллага байна.

Аудитын дүнгээр 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 897.3 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 2195.7 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдлөө.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас: (976)7042-2483, Факс: (976)7042-2483
Цахим шуудан: info@bo.gov.mn
Цахим хаяг: http://bayan-olgii.gov.mn/

2024. 06. 07 № 3-03/561

танай _____ -ны № _____ - т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайлантай танилцлаа.

Төлөвлөлтийн үе шат бүрийг Төрийн аудит хянаж, баталгаажуулж байх саналтай байна. Аудитын бусад зөвлөмжийг хүлээн авч зөрчлийг арилгаж ажиллана.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Х.БАХЫТГҮЛ

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй, төсөл арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслээгүй байна.
2. Төлөвлөсөн төсөл арга хэмжээний 89.5 хувь нь хэрэгжиж, тодорхой үр дүнг тооцоогүй байна
3. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулаагүй байна
4. Төсөл арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан эсэх талаар судалгаа хийгдээгүй байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I.Аймгийн ИТХ-ын дарга /Ш.Хабыл/-д:

1. Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.6-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, санхүүжилтийн эх үүсвэрээр/” гэсэн заалтыг баримталж тухайн онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төсөл арга хэмжээг төсөл арга хэмжээ тус бүрээр баталж ажиллах;

II. Аймгийн Засаг дарга /А.Камелият/-д:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төсвийн тухай хууль тогтоомж, холбогдох журамд нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх;
2. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулж, төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх;
3. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо холбогдох журмыг мөрдөж, бүрдүүлэх материалын иж бүрдлийг хангаж зөрчлийг давтан гаргахгүй байх;

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/09

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.1, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар, төлбөрийн акт, албан шаардлагыг 2 дугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга (А.Камелият)-д зөвлөсүгэй.

4. Аудитын дүнгээр өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (М.Айнур)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т тус тус даалгасугай.



Ж.АЙГҮЛ

00401031

